

**ШИНЭ КОРОНАВИРУСИЙН
ХАЛДВАРЫН ҮЕИЙН
ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТ
ХЯНАЛТ**

ХӨСҮТ

Халдварын сэргийлэлт, хяналтын арга хэмжээ

Халдвар дамжихаас сэргийлэхэд халдварын сэргийлэлт, хяналтын дараах стратегийг баримтлана:

- Эрт илрүүлэх, халдварын эх уурхайг хянах
- Бүх үйлчлүүлэгчдэд стандарт сэргийлэлтийг хэрэгжүүлэх
- Халдварын сэжигтэй тохиолдолд нэмэлт сэргийлэлтийг хэрэгжүүлэх (Дуслын болон хавьтлын сэргийлэлтийн арга хэмжээ)
- Удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ
- Орчин болон инженерын хяналт

1.Эрт илрүүлэх, халдварын эх уурхайг хяналтанд авах

Эмнэлэгт шинэ коронавирус (nCoV)-ийн халдварын сэжигтэй үйлчлүүлэгч илэрсэн даруйд бусад үйлчлүүлэгчээс тусгаарлах арга хэмжээ (тусгаарлах өрөө) авна.

Сэжигтэй тохиолдлыг эрт илрүүлэхийн тулд эмнэлэг дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай:


- Эрүүл мэндийн ажилтан уг өвчний эмнэлзүйн шинжийн талаар бүрэн мэдлэгтэй байх

- Илрүүлэг хийх асуумж ашиглах

- Эрүүл мэндийн ажилтанд анхааруулга өгөх зорилгоор уг халдварын үед илрэх шинж тэмдгийг сануулсан зурагт хуудас, бичлэг, санамж зэргийг нүдэнд харагдахуйц газруудад байршуулах.

Стандарт сэргийлэлт

- Гар угаах, халдваргүйжүүлэх
- Хувийн хамгаалах хувцас хэрэгсэл хэрэглэх
- Орчны цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийх
- Тарилгын аюулгүй байдлыг хангах
- Давтан хэрэглэж байгаа багаж хэрэгслийг цэвэрлэж, ариутгах
- Угаалга, хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх
- Зөв боловсон ханиах, найтаах



Халдвар
тархах
эрсдлийг
бууруулна

Гар угаах, халдваргүйжүүлэх

- Гар угаах (ус, шингэн саван, цаасан алчуур, 1 мин)
- Гар халдваргүйжүүлэх (70% -80 % спиртийн агууламж, 20-30 сек, тусламж үйлчилгээ үзүүлэх цэгт)
- Хэзээ?


Гар ариун цэвэр сахих 5 заалт

- Хяналт үнэлгээ
(ССГХБ-хэрэглээ, ажиглалт, нөхцөл)



Үйлдлийг бүрэн
гүйцэтгэх, бохир талбай
үлдээхгүй байх

Your 5 moments for HAND HYGIENE



Ханиаж, найтаах үеийн эрүүл ахуйн арга ХЭМЖЭЭ

- nCoV-ийн халдварын сэжигтэй тохиодолд амны хаалт зүүлгэх
- Сальфетка ашиглаж ам, хамраа бүрэн дарж ханиах, найтаах эсвэл тохой хэсгээр ам хамраа дарж ханиах, найтаах
- Ханиаж, найтаахдаа гараа бохирдуулсан тохиолдолд гарын эрүүл ахуй сахих

Үзлэг, эмчилгээ, үйлчлүүлэгчийн өрөөнд гар угаах, халдваргүйжүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.

Эмнэлгийн орох хэсэгт үйлчлүүлэгчид зориулсан амны хаалт, гарын эрүүл ахуй сахих боломжийг бүрдүүлсэн байна.

Үзлэг, оношилгооны өрөө бүрт эрүүл мэндийн ажилтан, үйлчлүүлэгчид хэрэглэх амны хаалт байна.

Халдваргүйжүүлэлт

Халдваргүйжүүлэх бодисыг хэрэглэх байдлаар нь:

- Гадаргууд хэрэглэх
- Багажинд хэрэглэх
- Хүний биед хэрэглэх антисептик гэж 3 ангилдаг

Үйлчлэх байдлаар нь:

- Бага түвшинд үйлчилгээ үзүүлэх (цэвэрлэгээ)
- Дунд түвшинд үйлчлэх
- Өндөр түвшний халдваргүйжүүлэгч

Хог хаягдлын менежмент

- Зөв ангилж, цуглуулах
- Шаардлага хангасан уут, сав, хайрцаг ашиглах
- Хэт дүүргэхгүй байх
- Зөв зөөх, тээвэрлэх
- Байгаль орчинд халгүй аргаар устгах



2.Нэмэлт сэргийлэлт буюу халдвар дамжих замд суурилсан сэргийлэлт

	Жишээ	Хаана тусгаарлах	Хамгаалах хувцас	Үндэслэл
Хавьтлын сэргийлэлт	Олон эмэнд тэсвэртэй нянгийн халдвар (MRSA, CD)	Хамгийн тохиромжтой нь нэг хүний өрөө	Халад, бээлий	Эмнэлгийн ажилтны гар, хувцас, б/х-ээр дамждаг
Дуслын сэргийлэлт	Менингококкт халдвар, хөхүүл ханиад, улирлын томуу	Нэг хүний өрөө, > 1 метрээс дээш тусгаарлалт	Нүдийг хамгаалах амны хаалт, нүүрний халхавч	1 метрээс дотогш зайд халдвар дамждаг
Агаар дуслын сэргийлэлт	Сүрьеэ, улаанбурхан, салхинцэцэг	Агаар дуслын халдвартай хүнийг тусгаарлах өрөө	N-95 эсвэл илүү өндөр шүүгчтэй амны хаалт	Агаар дахь 5 микроноос жижиг дуслаар халдвар дамждаг

Нэмэлт сэргийлэлт буюу халдвар дамжих замд суурилсан сэргийлэлт

- Нэг хүний өрөө хүрэлцээгүй, боломжгүй үед шинэ коронавирус (nCoV)-ийн халдварын сэжигтэй өвчтөнүүдийг хамт 1 өрөөнд тусгаарлах
- Өвчтөний ор хоорондын зай 1метрээс багагүй байх
- Халдвар тархах эрсдэлийг бууруулах зорилгоор боломжтой бол өвчтөнтэй харьцах ЭМА-ыг тусгайлан бэлтгэх
- Эмнэлгийн амны хаалт (нэг удаагийн амны хаалт) хэрэглэх
- Нүүрний хамгаалалт эсвэл нүдний шил хэрэглэх
- Урт ханцуйтай, шингэнд тэсвэртэй, 1 удаагийн халад өмсөх
- Бээлий өмсөх
- Багаж, хэрэгслийг аль болох нэг удаагийн эсвэл тухайн хүнд хэрэглэх байдлаар шийдэх. Чагнуур, даралтны аппарат, халууны шилийг үйлчлүүлэгч хооронд халдваргүйжүүлнэ.
- Халдвартай хэсэгт хүрэлцэж гараа бохирдуулсан бол нүд, хамар, аманд хүргэхээс зайлсхийх;

Нэмэлт сэргийлэлт буюу халдвар дамжих замд суурилсан сэргийлэлт

- Үйлчлүүлэгчийг өрөөнөөс гаргах, шилжүүлэхийг хориглоно. Хэрвээ тээвэрлэх тохиолдолд аль болох олон хүнтэй хавьтал болохоос сэргийлж хүргэх газарт урьдчилж мэдэгдэх, явах чиглэлийн коридори замыг чөлөөлөн, үйлчлүүлэгч болон эмнэлгийн ажилтантай хавьтал болохоос сэргийлэх. Үйлчлүүлэгчдэд амны хаалт зүүлгэх, эмнэлгийн ажилтан хамгаалах хувцас хэрэгсэл өмсөнө.
- Халдварын сэжигтэй үйлчлүүлэгчийг хүлээж авах өрөөг бэлтгэж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр ханган, халдвараас сэргийлэх бэлэн байдлыг хангана.
- Үйлчлүүлэгч хүрэлцдэг эмнэлгийн эд зүйл, тоног төхөөрөмжийн гадаргууг тогтмол цэвэрлэж, халдваргүйжүүлнэ.
- Эмнэлэгт тусгаарласан nCoV халдварын сэжигтэй үйлчлүүлэгчтэй хавьтал болох эргэлтийн хүмүүс, гэр бүлийн гишүүд, эмнэлгийн ажилтны тоог хязгаарлана.
- Үйлчлүүлэгчийн өрөөнд орсон бүх хүмүүс (Эмнэлгийн ажилтан, гэр бүлийн гишүүд, эргэлтээр ирсэн хүмүүс гэх мэт)-ийн бүртгэлийг хөтлөнө.

Тусгаарлах өрөө:

- Хаалганы гадна “сэрэмжүүлэг” хадна.
- Цэвэр цагаан хэрэглэлийг тусгаарлах өрөөнөөс гадна солих өрөөнд байлгана.
- Угаалтуур нь хэвийн ажиллагаатай байна.
- Спиртэнд суурилсан гар халдваргүйтгэх уусмалыг хүрэлцээтэй байлгана.
- “Биологийн аюултай” хаягтай хогийн уутыг хөлөөр онгойлгодог хогийн саван дотор байрлуулна.
- Өвчтөний хувийн эд юмсыг бага байлгах бөгөөд аяга, халбага, салфетка, хувийн ариун цэврийн хэрэгцээт бүх зүйлсийг өвчтөний гар хүрэх газар байрлуулна.
- Хувийн хамгаалах хэрэгслэл, халдваргүйтгэл, ариутгалын тоног төхөөрөмж бүхий таглаатай савыг хаалганы гадна байрлуулна.
- Цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн багаж хэрэгслийг тусгаарлах өрөөнд байлгаж, өдөр тутам чийгтэй цэвэрлэгээ хийнэ.

Аэрозол үүсгэх ажилбарын үеийн агаар дуслын сэргийлэлтийн арга хэмжээ:

- Үүнд: интубацийн гуурс тавих, авах, бронх дурандах, цагаан мөгөөрсөн хоолойд мэс засал хийх (трахеотоми), цагаан мөгөөрсөн хоолойд интубацийн гуурс тавих гэх мэт
- Аэрозол үүсгэдэг ажилбар хийж гүйцэтгэх эрүүл мэндийн ажилтанд:
- Шүүлтүүртэй нэг удаагийн амны хаалт хэрэглэх, халдвартай агаарын дуслыг 95% буюу түүнээс дээш шүүх үзүүлэлттэй байх. Битүүмжлэлийг шалгана , нэг удаа хэрэглээд хаяна.
- Нүдний шил эсвэл нүүрний хамгаалалт;
- Цэвэр, урт ханцуйтай нэг удаагийн халад эсвэл комбинзон, бээлий;
- Хэрвээ шингэнд тэсвэртэй биш халадтай үед шингэн үсрэх, цацагдах, нэвтрэх эрсдлээс сэргийлж усны хамгаалалттай хормогч нэмэлтээр өмсөнө.
- Өрөөнд байх хүний тоог хязгаарлах (өвчтөнд тусламж үзүүлэх хүний тоог хязгаарлана)

3.Удирдлагын хяналт, зохион байгуулалт

- Халдварын сэргийлэлт, хяналтын дэд бүтэц, үйл ажиллагааг бэхжүүлэх;
- ЭМА-ы сургалт;
- Амьсгалын замын хурц халдвартай болон шинэ коронавирусийн (nCoV) халдварын тохиолдлыг эрт илрүүлэх бодлогыг хэрэгжүүлэх;
- Шалтгааныг тогтоох, лабораторийн шинжилгээ шуурхай байх;
- Яаралтай тусламжийн хэсэгт хэт их ачаалал үүсэхээс сэргийлэх;
- Шинж тэмдэг бүхий өвчтөнд зориулагдсан хүлээлгийн хэсгийг шийдвэрлэх, хэвтэн эмчлүүлэгчдийг зөв байршуулах, эмнэлгийн ажилтны тоог (эмнэлгийн ажилтан-өвчтний харьцаа) нэмэгдүүлэх;
- Шаардагдах хангамж, нөөцийг нэмэгдүүлэх;
- ЭМА-ы дунд амьсгалын замын хурц халдварын шинж тэмдэгийн тандалт хийх, ЭМА-ы ажилбар гүйцэтгэх үйл ажиллагаанд хяналт тавих

4. Орчин ба инженерийн хяналт

- Үүнд эрүүл мэндийн байгууллагын үндсэн дэд бүтэц хамаарна. Эрүүл мэндийн байгууллага дахь бүх хэсгийн агааржуулалт, орчны цэвэрлэгээг сайжруулна. Сэжигтэй тохиолдлыг бусад үйлчлүүлэгчээс 1 метрээс багагүй зайтай байхаар тусгаарлалтыг хийнэ. Орчин ба инженерийн хяналт нь эмнэлгийн орчинд эмгэгтөрөгч тархах эрсдэлийг бууруулна.

Анхаарал
тавьсанд баярлалаа.